

Монгол хэлний “у”, “w” гийгүүлэгч  
дэвсгэрлэдэг байсан уу?

Д. Заяабаатар\*  
(Дангүг Их сургууль)

Монгол хэлшинжлэлийн бүтээлүүдэд дурдагддаг 11 дэвсгэр үсэг хэмээх ойлголт буй. Чойжи-Одсэрийн “Зүрхний толт”-д “*an kiged ab ba, ay kiged am ba, al kiged ar ba, as kiged ad ba ay kiged aw ba, ang luᠭ a arban nigen dang debisker*”<sup>1</sup> гээд, эр үгэнд орвол чанга, эм үгэнд орвол хөндий дэвсгэр болно хэмээн тодорхойлжээ. Эдгээр 11 (*n, m, l, ng, b, ᠶg, r, d, s, w, y*) дэвсгэр гийгүүлэгчээс 9 (*n, m, l, ng, b, ᠶg, r, d, s*) нь орчин цагийн монгол хэлэнд үе төгсгөн ордог. Харин *y, w* хоёр гийгүүлэгч хадгалагдан үлдсэнгүй.

Академич Ш. Лувсанвандан “Эртний монгол хэлний үе төгсгөх *y, w* гийгүүлэгч орчин цагийн монгол хэл аялгуунд гол төлөв урт буюу хос эгшигт шингэн нийлсэн байна. Жишээлбэл: *tawlaytaulaityūā* г.м. Үүнийг Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов 1929 онд Ленинград хотноо хэвлүүлсэн “*Сравнительная грамматика монгольского языка и халхаского наречия. Введение и фонетика*” гэсэн алдарт бүтээлдээ нарийвчлан судалсан байна”<sup>2</sup> гэжээ.

Үнэхээр, академич Ш. Лувсанвандан багштаны тэмдэглэсэнчлэн, нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцовын алдарт хэлзүйгээс<sup>3</sup> улбаатай, угтаа Чойжи-Одсэрийн “Зүрхний толт”-оос эхтэй “*y, w* дэвсгэр” гэх ойлголт монгол хэлний судлалд нэгэнтээ хэвшжээ.

Гэвч “*y, w* дэвсгэр”-ийг хэрхэн тэмдэглэж байсан бэ, 11 дэвсгэрээс энэ хоёр гийгүүлэгч орчин цагийн монгол хэлэнд яагаад уламжлан ирсэнгүй вэ, тэдгээрийн ул мөр болон үлдсэн ямар баримт байна гэх зэрэг сайтар магадлуштай зүйлс байна.

Юуны өмнө, хэлзүйн бичгүүдэд *y, w* дэвсгэрийн талаар хэрхэн тодорхойлж, ямар жишээ баримт татсаныг тодруулья.

Чойжи-Одсэрийн “Зүрхний толт”-д тодорхой жишээ оноосонгүй харин “*ayil metü inü dabqur debisker bolai. ...dabqur debisker inü eyin metü bolai*”<sup>4</sup> гэхчилэн дурдаж буйгаас үзвэл, *l, n* дэвсгэрийн өмнө орсон “хоёр шилбэ” буюу “хоёр йод”-ийг *y* дэвсгэр мэтээр ухаарч байсан ажээ.

\* МУИС-ийн багш. БНСУ-ын Дангүг их сургуулийн урилгын багш.

<sup>1</sup> “*Jirüken-ü tolta-yin tayilbur*” *oᠭtarᠶui-yin mani kemekü sudur orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 8-р тал.

<sup>2</sup> Ш. Лувсанвандан, *Эртний монгол хэлний фонемын систем нь*, МС:5 (2), Улаанбаатар, 1965, 32-р тал.

<sup>3</sup> Нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов харьцуулсан хэлзүйдээ *taulai, ᠵouqur, keiken, qauli, teike* гэх зэрэг үгийн урт эгшигийг \*awawū, \*owowū, \*ewewū гэж сэргээснийг эрдэмтэд даган баримталсаар иржээ.

<sup>4</sup> “*Jirüken-ü tolta-yin tayilbur*” *oᠭtarᠶui-yin mani kemekü sudur orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 8-9.

Энэ нь хожмын хэлзүйн бичгүүдэд шууд нөлөөлсөн бөгөөд Агваандандар “Хэлний чимэг”-тээ:

*“a ača wa kürtel\_e arban naiman toluγai üsüg-eče na ba γa ma la ra sa da ya wa arban üsüg kiged edeger-ün deger\_e ng nemegeд arban nigen üsüg-i debisker kememüi. Basa egün-eče ya debisker-ün door\_a na γa ma la ra sa da terigüten doluγan üsüg debiscü bolqu tula ene doluγan üsüg-i dabgur debisker čü kememüi. Üligerlebesü toyin toyiγ oyim ayil čayir jayis sayid metü bui”*<sup>5</sup>,

Лхамсүрэн “Алтан моль”-доо:

*“wa anu dumdadu dur da (= ᠠ Д. 3.) debisker-ün adali böged sidü ügei (= ᠠ Д. 3.), adaγ-tur ba (ᠪᠢ) üsüg-ün toluγai adali (= ᠪ Д. 3.) bičimüi. qauli eregüü metü”, “ya anu dumdadu-dur imayta qoyar urtu silbi (= ᠠ Д. 3.) bičikü..., adaγ-tur imayta ersü üsüg-ün segül (= ᠢ Д. 3.) adali bičimüi. Adalidqabasu uyidqarlaqu üiles eyimü berketei kemegsen metü”*<sup>6</sup> гэх зэргээр тайлбарлажээ. Мөн Агваандандар *sonusquy\_a, jiu\_a, γaqai, degüü* зэрэг жишээ татсан байна.

Монгол хэлзүйн бичгүүдэд “у, w” дэвсгэрийг тодорхойлсон байдлаас хэдэн зүйлийг ажиглаж болно.

1. Чойжи-Одсэр үгийн дунд орсон хоёр шилбэ ( ᠠ ) буюу *yi* үеийг дэвсгэр гэж ухаарсан нь илэрхий байна.
2. *w* дэвсгэрийг үгийн дунд ᠠ, эцэст ᠪ гэж тэмдэглэнэ.
3. *y* дэвсгэрийг үгийн дунд ᠠ, эцэст ᠢ гэж тэмдэглэнэ.
4. ᠠᠶᠢᠯ *ayil*, ᠠᠶᠢᠨ *eyin*, ᠲᠣᠶᠢᠨ *toyin*, ᠲᠣᠶᠢᠭ *toyig*, ᠰᠠᠶᠢᠳ *sayid*, ᠤᠶᠢᠳᠠᠷᠠᠯᠠᠭᠤ *uyidqarlaqu*, ᠤᠶᠢᠯᠡᠰ *üiles*, ᠡᠶᠢᠮᠤ *eyimü*, ᠪᠡᠷᠬᠡᠲᠡᠢ *berketei*, ᠶᠠᠴᠠᠢ *γaqai* зэрэг нь *y* дэвсгэртэй, ᠶᠠᠯᠢ *qauli*, ᠡᠷᠢᠭᠦᠭ *eregüü*, ᠵᠢᠤ *jiu\_a*, ᠳᠡᠭᠦᠭ *degüü* зэрэг нь *w* дэвсгэртэй үг ажээ.

Эндээс харахад л, “у, w дэвсгэр” гэдэгт эргэлзээтэй зүйл олон байна. Үүнээс үүдэж, мөнхүү хоёр гийгүүлэгчийн хэвшинжийн талаар цухас ажиглалт хийв.

[w] Ер нь Гунгаажалцаны “Зүрхний толт”-оос эх үүдэлтэй, хожмын хэлзүйн бичгүүдэд уламжлан дурдагдсан *wa, we* үсгээр чухам ямар авиалбарыг тэмдэглэж байсан бэ, бас яаж бичсэн бэ гэдэг асуудал тун сонирхолтой юм.

Саж бандид монгол бичгийн цагаан толгойн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо *wa, we* гэж *a, e* эгшгээр амилуулсан атлаа яагаад *wi* гэж *i* эгшгээр амилуулсангүй вэ? Хэрвээ *w* үсэглэврийг хэлсэн бол ᠠ гэж амилуулан бичих боломж ч байсан, шаардлага ч байсан. Тийм үе орсон харь хэлний үгийг монгол бичгийн дурсгалд тэмдэглэсэн баримт *virenggüid, vinai* гэх мэтээр цөөнгүй тохиолддог. Энд нэг учир байна. Чойжи-Одсэр “Зүрхний толт”-доо бүх гийгүүлэгчийг долоон эгшгээр амилуулахдаа “хязгаар дахь хоёр” буюу *wa, we* хоёрыг эс хувилгасны зангилаа ч эндээс тайлагдана.

Үүний учир начрыг тодруулах чухал сэжүүрийг Агваандандар “Хэлний чимэг”-тээ дурдсан байна. Тэрбээр *“basa wa we qoyar üsüg mongγol-ün üges-tür bui böged wi, wo, wu, wö, wü ene tabun üsüg mongγol-ün üges-tür ülü kereglekü böged üsüg-ün debisker-tür čü ülü keregsekü-yin tula čayan toluγai-dur qasujuqu”* гэж тэмдэглэжээ.

<sup>5</sup> Ayvangandar, *Mongγol kelen-ü yosun-i sayitur nomlaγsan kelen-ü ämeg kemegdekü orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 24-25.

<sup>6</sup> Lhamusürüng, *Mongγol üsüg-ün yosun-i todurqayilan γarγaγsan altan toli kemegdekü orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 44-р тал.

Эндээс харахад, Гунгаажалцаны дурдсан *wa, we* үсэглэвэр харь хэлний үгийг тэмдэглэх *w* авиатай холбогдох нь гарцаагүй байна. Харин тэрхүү *w* гийгүүлэгчийг яаж тэмдэглэж байсан бэ?

Бидний санахад, монгол бичгийн хөгжлийн эрт үед харь үгэнд тохиолдох *w* гийгүүлэгчийг хоёр янзаар тэмдэглэж байжээ. Тэдгээр нь *ʋ* болон *ᠪᠷ* ( *~ ʋᠷ* ) хэлбэр юм. Харин *w* гийгүүлэгчийн үгийн эцэст орох хэлбэрийг *ᠪᠷ* ( *ʋᠷ* ) гэж тэмдэглэх ёсыг Гунгаажалцан, анх журамласан байж мэднэ.

Өөрөөр хэлбэл, Саж бандид Гунгаажалцан "Зүрхний толт"-доо цагаан толгойн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо монгол хэлний уугуул үгийг тэмдэглэхэд оролцох үндсэн үсэглэврүүдийг л оруулах зарчим барьсан бололтой. Нэгэнт ийм шалгуур тавьсан болохоор харь үгийг тэмдэглэдэг *w* үсэглэврийг оруулсангүй, харин түүний эцэст орох хэлбэрийг *ᠪᠷ* ( *~ ʋᠷ* ) гэж тэмдэглэхээр журамлажээ. Тэгэхээр Гунгаажалцаны "Зүрхний толт"-д дурдагдаж буй *wa, we* бол *ᠪᠷ* цогц юм.

Энэ ч бас учиртай. Харь үгийг тэмдэглэх үүрэгтэй *w* гийгүүлэгчийн монгол хэл аялгуунд авиалагдах байдал нь *ua (ya)* нийлэмжтэй их ойр байсан биз ээ. Үүний ул мөрийг *ᠪᠲᠠᠷᠳᠠᠭᠠᠭᠢ* ~ *ᠪᠲᠠᠷᠳᠠᠭᠡᠭᠡᠭᠡ*, *ᠪᠲᠠᠷᠳᠠᠭᠡᠭᠡᠭᠡ* гэх зэргээр тэмдэглэдэг хувилбар бичлэг бүхий үгсээс харж болно. Мөн түүхэн сурвалж бичгүүдэд *ᠪᠲᠠᠷᠳᠠᠭᠡᠭᠡᠭᠡ* ( *~ ʋᠲᠠᠷᠳᠠᠭᠡᠭᠡᠭᠡ* Д.3) гэж бичдэг нь үүнтэй холбогдох баримт юм. Эрдэмтэн Мандах "үгийн эцэст орсон *ᠪᠷ* хэлбэр голдуу *wa*: авиаг илтгэнэ" гэжээ.

Цаашилбал, Гунгаажалцан "Зүрхний толт"-доо уруулын эгшгүүдийг дурдаагүйн учрыг тодруулах шижим ч эндээс гарч байна. Үнэхээр, академич Д. Төмөртогоо багшийн дурдсанчлан, Саж бандид уруулын эгшгүүдийг *w* гийгүүлэгч авиалбарын хувилбарууд гэж бодсон байхыг үгүйсгэх аргагүй<sup>8</sup>. Академич Б. Ринчен "... ва дэвисгэр гэдгийн уг сурвалж нь мөн түрэг уйгур бичгийн үсэгзүйн аман уламжлал буюу манай өвөг хятан гэдэг монголчуудын хэл бичгийн уламжлал байж болзошгүй"<sup>9</sup> гэж тэмдэглэсэн байдгийг дурдалтай.

[y] Монгол бичгийн зөв бичих зүйн зарчим *y* гийгүүлэгч үгийн эцэст тохиолдохгүй буюу утгаа дэвсгэрлэн ордоггүй гэдгийг илтгэдэг. Агваандандар "Хэлний чимэг"-тээ:

*"i ene inü arban nigen debisker-ün ya wa qoyar-ača busu bügüde-yin segül-dür bičikü... ,*  
*"yi ene inü debis ker ügei üsüg bügüde-yin segül-dür bičikü ba basa ya, wa qoyar debisker-ün segül-dür bičimüi. Üligerlebesü ... yaqai-yi degüü-yi", yin ene inü debisker ügei üsüg bügüde-yin segül-dür bičikü ba basa ya wa qoyar debisker-ün segül-dür cü bičikü... Üligerlebesü... yaqai-yin kүү-yin"* гэж тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, *ai ei* ( *ʋ* ) *ui, üi* ( *ʋ* ) цогцоор төгссөн үед ямагт гийгүүлэгчээр эхэлсэн бүтээвэр залгана. Харин эрдэмтэн Ж. Надмид гуайн дурдсанчлан<sup>10</sup>, *noqai* *ᠲᠠᠭᠢᠳᠠᠭᠡᠭᠡ* гэсэн үгийг уртасган бичихэд, *ᠲᠠᠭᠢᠳᠠᠭᠡᠭᠡᠭᠡ* *noqayitaqu* болдог нь мөнхүү *ai* цогцын *ʋ* үсэглэвэр *y* гийгүүлэгч

<sup>8</sup> Сонгодог бичгийн өмнөх зарим дурсгалд уруулын эгшгийн эцэст орох хэлбэрийг дан гэдсээр (ʋ Д. 3.) тэмдэглэсэн тохиолдол таардгийг энд анхаарвал зохино.

<sup>7</sup> Ө. Manduqu, *Monggol üsüg-ün ctemdeg ba tegün-ü jöb dajudaly\_a*, "Монгол хэлний судлал", ÖMSKKQ, 1990, 343-р тал.

<sup>8</sup> Д. Төмөртогоо, *O wa, we "Jiriken-ü tolta"* Саж бандида Гунгааджалцана, Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 477-р тал.

<sup>9</sup> Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Дэд дэвтэр, Авиан зүй, Улаанбаатар, 1966, 90-р тал.

<sup>10</sup> Ж. Надмид, *Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм*, Улаанбаатар, 1967, 28-р тал.

байсны нуталгаа болохгүй, үгийн эцсийн бус хос эгшиг *Vu* биш *Vyi* цогцоос ирэлтэй гэдгийн гэрч юм.

Академич Б. Ринчен “у дэвсгэр” гийгүүлэгч үгийн дунд *ᠠ* (-*йи*, -*yi*), адагт *ᠡ* (-*и*, -*i*) хэлбэртэй болохыг зааж, энэ нь энэтхэг төвдийн үе үсэг, эсвэл уйгур хэлний нөлөө тусгал ч байж болохыг дурдан тэмдэглээд, “эл гийгүүлэгч хэмээн үздэг байсан у дэвисгэрийн сүүлд ордог тийн ялгалын дагаварын зүйл нь, цөм задгай үеэр төгссөн үгийн сүүлд ордог дагавар байдаг нь, *йа* дэвисгэр уг чанартаа гийгүүлэгч авианы тэмдэг хэрхэвч бишийг давхар батлан заах ажгуу”<sup>11</sup> хэмээсэн даацтай дүгнэлт хийжээ.

Тэгвэл, “у, w дэвсгэр”-тэй гэж тодорхойлсоор ирсэн эш баримтыг хэрхэн үзэх вэ?

Эртний монгол хэлний *ayú*, *egú* цогцын түүхэн хувьслын нэгэн шат болох *ay*, *eü* нийлэмжийг монгол бичгийн зөв бичих зүйд шууд тусган тэмдэглэснийг *aw*, *ew* буюу VC цогц гэж үзэх хандлага байжээ. Өөрөөр хэлбэл, монгол хэлний түүхэн судлалын ихэнх бүтээлд *w* дэвсгэртэй үг хэмээн жишээлсээр ирсэн *taulai*, *teüke*, *keüken*, *keüked*, *qauli* зэрэг нь арынхаа урт эгшгийн нөлөөгөөр сулран сугарсан *g*, *γ* гийгүүлэгчийн хоёр талын эгшиг нийлсэн боловч хараахан ижилшиж амжаагүй байх үеийг тусган бичсэнээс үүдэлтэй, бичгийн хэлэнд хэвшсэн хэлбэр гэж үзэж байна.

Үгийн дунд орсон *ᠠ* бол *yi* үе бөгөөд адагт тэмдэглэсэн *ᠡ*, *ᠢ* цогц нь *ay*, *ey*, *üy* *üy* бус задгай үеийн *ai*, *ei*, *ui*, *üi* хос эгшгийг шууд тусган тэмдэглэсэн хэрэг юм.

Тэгэхээр, өнөөг хүртэл *у*, *w* дэвсгэр хэмээн хэлэлцсээр буй ойлголтын мөн чанар, хэвшил хэрэглээ, эш баримтыг нягтлан ажиглахад үе төгсгөн ордог байсныг нутлах баттай баримт олдохгүй байна. Түрэг хэлэнд *tabišqan*, *taušan* гэх мэтээр тохиолддог нь *w* гийгүүлэгч дэвсгэрлэж ордог байсны ул мөр мөн эсэхийг сайтар тодруулах хэрэгтэй юм. Харин нөгөө талаас нь, арынхаа урт эгшгийн нөлөөгөөр сулран сугарсан *\*ɣ\*<sup>w</sup>* гийгүүлэгчийн хоёр талын эгшиг хараахан ижилшин амжаагүй байх цагт *taulai* хэмээх үг монгол хэлнээс түрэг хэлэнд оржээ гэж үзэх боломж гарахыг ч үгүйсгэх аргагүй. Энд *w* гийгүүлэгч хийгээд *u*, *ü* эгшгүүдийн авианы ойролцоо шинжийг бас бодолцвол зохино. Мөн *у*, *i* хоёр авиа бүтэх байр, аргын хувьд ойролцоо болохыг анзааралгүй өнгөрч болохгүй биз ээ.

Гэвч энэ бол өгүүлэл бичигчийн хэлж буй таамгийн төдий л зүйл болохоос, урьд өмнөх эрдэмтдийн үзэл онолыг уг үндсээр үгүйсгэх хөдөлшгүй баримт биш гэдгийг дурдах нь зүйтэй.

Эцэст дүгнэн хэлэхэд, уламжлалт хэлшинжлэлийн сурвалж бичгүүдэд,

- үгийн дундах *’yi’* үе буюу хоёр шилбэ (*ᠠ* Д. 3.), мөн *у* гийгүүлэгчийн “орхиц”-ын (*а*, *е* эгшиг Д. 3.) өмнө тохиолдох *ᠡ* хэлбэр (*ᠡ* Д. 3.) ба задгай үеийн хос эгшгийн бүрэлдэхүүн дэх *’i’* эгшгийг *у* дэвсгэр;
- харь үгэнд ордог *w* (*ᠡ* Д. 3.) гийгүүлэгч үгийн эцэст тохиолдохдоо хэрхэн авиалагдах байдлыг тусгахын зэрэгцээ монгол бичгийн үндсэн үсэглэврээр тэмдэглэх журмыг тогтоосноос үүдэлтэй бий болсон *ᠡ* цогцын *ᠡ* хэлбэрийг “*w* дэвсгэр” гэж үзэж байсныг хожмын эрдэмтэд янз бүрээр ухаж ойлгосны улмаас “арван нэгэн дэвсгэр үсэг” хэмээх зохиомол нэрлэлт монгол хэлний судлалд нэгэнтээ хэвшжээ.

<sup>11</sup> Б. Ринчен, *Монгол бичгийн хэлний зүй*, Дэд дэвтэр, Авиан зүй, Улаанбаатар, 1966, 90-91.

Үүнээс улбаалж, "w, y дэвсгэр" гэдэгт элдэв жишээ оноож ирсэн нь монгол хэлний авианы түүхэн хувьслыг тайлбарлахад зарим талаар будлиан тарьсан бололтой. Өөрөөр хэлбэл, уламжлалт хэлшинжлэлийн зарим сурвалж бичгээс эхтэй үсэглэврийн хувилбарт холбогдох ойлголтыг авианы үзэгдэл болгон тайлбарласан нэгэн зүйлийн ташаарал байжээ.

Өмнө дурдсан үзэл саналын үнэний хувь нь илүү аваас, монгол хэлний түүхэн хөгжлийн эрт үед *y*, *w* дэвсгэр гэж байсангүй бөгөөд ерөөсөө үе төгсгөн ордог 9 гийгүүлэгч л байжээ гэдгийг дүгнэн хэлэх боломжтой байна. Тэдгээр 9 дэвсгэр гийгүүлэгч орчин цагийн монгол хэлэнд мөн адил хадгалагдаж байгаа бөгөөд *n*, *m*, *l*, *ng*, *b*, *ɣg*, *r*, *d*, *s* болно.

## АШИГЛАСАН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- Агвандандар., *Mongᠭol kelen-ü yosun-i sayitur nomlaᠭsan kelen-ü čimeg kemegdekü orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 22-30.
- Владимирцов Б.Я., *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, Введение и фонетика, Ленинград, 1929, 437 стр.
- "Jirüken-ü tolta-yin tayilbur" *оᠵтарγui-yin mani kemekü sudur orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 3-21.
- Лувсанвандан Ш., *Эртний монгол хэлний фонемын систем нь*, МС:5 (2), Улаанбаатар, 1965, 3-47.
- Lhamusürüng, *Mongᠭol üsüg-ün yosun-i todurqayilan γarγaᠭsan altan toli kemegdekü orosibai*, MKSDB, Köke qota, 1983, 38-51.
- Manduqu Ö., *Mongᠭol üsüg-ün ɛ temdeg ba tegün-ü jöb daᠭudalᠭ\_a*, "Монгол хэлний судлал", ÖMSKKQ, 1990, 332-344.
- Надмид Ж., *Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм*, Улаанбаатар, 1967, 129 тал.
- Ринчен Б., *Монгол бичгийн хэлний зүй*, Дэд дэвтэр, Авиан зүй, Улаанбаатар, 1966, 402 тал.
- Төмөртоого Д., *О wa, we "Jirüken-ü tolta" Сажа бандида Гунгааджалцана*, Монгол хэлшинжилэлийн онол түүхийн асуудалууд, Улаанбаатар, 2002, 475-479.

## REMARKS ON THE CLOSING CONSONANTS 'y' AND 'w' IN MONGOLIAN

Choi-ji-Odser's "*Jirüken-ü tolta*" was a strong influence on the sources of the traditional linguistics. In addition to this, after the appearance of Vladimirtsov's "*Comparative grammar of the Written Mongolian and Khalkha Dialect*", the influence of the Mongolists became that of the detailed study of the grammar of the Mongolian languages. One of these influences which is so-called closing consonants 'y' and 'w'.

The phoneme *w* ( ɤ Д. 3) is marked by two versions: ɤ and ɛ ( ~ ɤ Д.3) in foreign words of the preclassical period. In ancient manuscripts and in old xylographic editions of the preclassical period, the ɤ is used at the initial form of words such as ɤᠠᠭᠤ, ɤᠠᠭᠤᠨ. The ɛ version is used at the end of words before *a*, *e* written separately from the word such as ɛᠠᠭᠤᠨᠠ, ɛᠠᠭᠤᠨᠡ. The linguists who studied the historical phonetics of Mongolian languages were considered the ɛ as the closing consonant.

The syllable 'yi' in middle of words and form ɛ consonant 'y' before the vowels *a* or *e* written separately from words (i.e., *орхуц*) as well as vowel 'i' in the combination of the word final diphthongs is considered as the closing consonant 'y'.

Summing up of this small article, consonants 'y' and 'w' do not occur at the end of words or syllables of the Mongolian languages.

## KEYWORDS

Historical development of the Mongolian language · Preclassical Written Mongolian · Sources of the traditional linguistics · Syllable closing consonants